

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариуг сонгоорой.

1. Монгол орны өмнө захын цэг аль нь вэ? /1 оноо/
 А. Өвөрхөшөөтийн булаг В. Монгол Шарын даваа С. Таван Богдын Мааньт
 D. Соёлз уулын Модтой Хамар даваа E. Орвог Гашууны Бор толгой уул
2. Масштабыг бичиглэх хэлбэрээр нь ангилсан бүдүүвчийг гүйцээж нөхөөрэй. /1 оноо/



- A. Босоо масштаб
- B. Үсгэн масштаб
- C. Тойргон масштаб
- D. Шугаман масштаб
- E. Ташуу масштаб

3. Үхэр сүргийн тоо толгойгоор тэргүүлэгч аймаг аль нь вэ? /1 оноо/
 А. Өмнөговь В. Говь-Сүмбэр С. Орхон D. Дархан-Уул E. Архангай
4. Өвөл манай оронд их даралтын төв (эсрэг циклон) хаана тогтдог вэ? /1 оноо/
 А. Увс нуурын хотгор В. Хангайн нуруу С. Дорнодын тал
 D. Халхын тэгш өндөрлөг E. Алтайн өвөр говь
5. Экваторын шугам нь өргөргийн хэдэн градус вэ? /1 оноо/
 А. 66,5° В. 23,5° С. 0° D. 45° E. 90°
6. Манай дэлхийн цорын ганц дагуулыг сонгоно уу. /1 оноо/
 А. Цолмон В. Сар С. Айдас D. Сугар E. Ангараг
7. Дараах таних тэмдэг газарзүйн зурагт юуг илэрхийлэх вэ? /1 оноо/




- A. Барилга
- B. Навчит ой
- C. Өндөр хүчдэлийн шугам
- D. Гүүр
- E. Уул

8. Далайн хамгийн их давсжилттай тэнгис аль нь вэ? /1 оноо/
 А. Карын тэнгис В. Гренландын тэнгис С. Бофортын тэнгис
 D. Чукотын тэнгис E. Улаан тэнгис
9. Мөнх цас, мөстлөггүй хуурай газрыг сонгоно уу. /1 оноо/
 А. Австрали В. Еврази С. Антарктид D. Хойд Америк E. Африк
10. Төвийн аймгууд эрчим хүчээ хаанаас импортолж авдаг вэ? /1 оноо/
 А. Улаанбоом УЦС В. Дөргөн УЦС С. Хуншаньзюй ДЦС
 D. Чойбалсан ДЦС E. Галуут нуур ДЦС
11. Дөрвөд ястны олонх нь амьдардаг аймаг аль нь вэ? /1 оноо/
 А. Сэлэнгэ В. Өвөрхангай С. Дорноговь D. Увс E. Хэнтий



12. Чойбалсан хот нь аль эдийн засгийн бүс нутгийн тулгуур төв бэ?

/1 оноо/



- A. Баруун
- B. Улаанбаатарын
- C. Төвийн
- D. Хангайн
- E. Зүүн

13. Нарны аймгийн хамгийн олон дагуултай гарагийг сонгоно уу.

/1 оноо/

- A. Санчир
- B. Сугар
- C. Далай ван
- D. Буд
- E. Ангараг

14. Дэлхийн хамгийн гүн, цэнгэг уст нуур аль нь вэ?

/1 оноо/

- A. Дээд
- B. Их Давст
- C. Байгал
- D. Виктори
- E. Арал

15. Том хотуудын ойролцоо, дэд бүтэц сайн хөгжсөн жижиг хотууд үүсэх үзэгдлийг юу гэж нэрлэдэг вэ?

/1 оноо/

- A. Мегалополис
- B. Дагуул хот
- C. Бүлэг тосгон
- D. Хотын тэсрэлт
- E. Агломераци

16. Хангай нурууны ноён оргилыг сонгоно уу.

/1 оноо/

- A. Тарвагатай
- B. Хан-Хөхий
- C. Ноёнхангай
- D. Отгонтэнгэр
- E. Бүтээл

17. Ойт хээрийн бүсийн амьтныг сонгоно уу.

/1 оноо/



- A. Бөхөн
- B. Хонин гүрвэл
- C. Халиун буга
- D. Мазаалай
- E. Хулан

18. Хангай нуруунаас эх авч Сэлэнгэ мөрөнд цутгадаг, Хойд мөсөн далайн ай савд хамаарагдах гол аль нь вэ?

/1 оноо/

- A. Онги
- B. Бодонч
- C. Таац
- D. Орхон
- E. Хэрлэн

19. Төмөрлөг бус ашигт малтмалын төрөлд аль нь хамаарах вэ?

/1 оноо/

- A. Гянт болд
- B. Цайр
- C. Хөнгөнцагаан
- D. Мөнгө
- E. Давс

20. Зэсийн баяжмал үйлдвэрлэдэг компани аль нь вэ?

/1 оноо/

- A. Эрдэнэт
- B. Таван толгой
- C. Энержи ресурс
- D. Бороо гоулд
- E. Гачуурт

21. 3-р сарын 21-нд нар хаана эгц тусах вэ?

/1 оноо/

- A. Хойд туйлын цагариг
- B. Матрын зам
- C. Мэлхийн зам
- D. Экватор
- E. Өмнөд туйл


22. Өндөр хөгжилтэй орон аль нь вэ? **/1 оноо/**
 А. Нигер В. Канад С. Алжир D. Тайланд E. Тунис
23. Малын хэт төвлөрлөөс болж бэлчээр доройтохыг юу гэж нэрлэдэг вэ? **/1 оноо/**
 А. Харын зуд В. Цагаан зуд С. Туурайн зуд D.Ган E. Өн болох
24. Энэтхэг, Бангладеш улсуудын нутгаар дамжин урсдаг мөрөнг сонгоно уу. **/1 оноо/**
 А. Хөх мөрөн В. Инд С. Амар мөрөн D. Ганга E. Меконг
25. Сайншанд өртөөнөөс салаа төмөр замаар аль сууринд очих боломжтой вэ? **/2 оноо/**



- А. Шарын гол
 В. Бор-Өндөр
 С. Салхит
 D. Багануур
 E. Зүүнбаян

26. АНУ-ын Лос-Анжелос хотод агаарын температур дээшлэх тусам нэмэгдэх үзэгдэл буюу температурын инверс үүсдэг шалтгааныг сонгоно уу. **/2 оноо/**
 А. Агаарын бохирдол В. Шороон шуурга С. Хүчлийн бороо
 D. Хар салхи E. Хөрсний элэгдэл

27. Дараах улс орнуудын нутаг дэвсгэрийн газарзүйн зургийг ажиглаад аль нь Мексик улс болохыг тодорхойлоорой. **/2 оноо/**



28. Өндөр уулын бүслүүрийн вансэмбэрүү, сибир алтанхундага болон хандгай, зэрлэг цаа бугын гол байршил нутгийг хамгаалах үндэслэлээр 1997 онд улсын тусгай хамгаалалтад авсан газрыг сонгоно уу. **/2 оноо/**

- А. Уран уул ДГ В. Горхи Тэрэлж БЦГ
 С. Хан Хөхий-Хяргас нуур БЦГ D. Хорьдол Сарьдаг ДЦГ E. Ээж хайрхан ДГ

29. Та Хойд Америкийн хойд хэсгээр аялахдаа доорх уугуул иргэдийн алиных нь соёл, зан заншил, ахуй амьдралтай танилцаж судалгаа хийх вэ? **/2 оноо/**

- А. Бушмен В. Аброген С. Эксимос D. Массай E. Бербер

30. Газарзүйн зурагт тэмдэглэсэн А цэгийн байршил дээрх газрын нэрийг олоорой. **/2 оноо/**



- А. Мадагаскар арал
 В. Килиманжаро уул
 С. Намибын цөл
 D. Баб-Эль-Мандебын хоолой
 E. Кайр хот

31. Билгийн тооллын хэдний шөнө сар тэнгэрийн мандалд харагдахгүй вэ? **/2 оноо/**

- A. Шинийн арван таван B. Битүүн C. Хуучдын хорин
D. Хуучдын арван найман E. Шинийн долоон

32. Органик гаралтай тунамал чулуулгийг сонгоно уу. **/2 оноо/**

- A. Хайрга B. Хүрмэн чулуу C. Элс D. Гантиг E. Нүүрс

33. Байгалийн төрх байдлыг голлон ургадаг ургамалтай нь зөв тохируулаарай. **/2 оноо/**

1	Говь	a	Хялгана
2	Тайга	b	Цээнэ
3	Хээр	c	Шинэс
4	Нуга	d	Заг

- A. 1-a, 2-c, 3-b, 4-d
B. 1-d, 2-c, 3-a, 4-b
C. 1-c, 2-a, 3-d, 4-b
D. 1-b, 2-a, 3-c, 4-d
E. 1-c, 2-b, 3-a, 4-d

34. “Google earth” программаас авсан зургийг ажиглаад аль нуур болохыг олоорой **/2 оноо/**



- A. Дөргөн нуур
B. Увс нуур
C. Хяргас нуур
D. Хар-Ус нуур
E. Хөвсгөл нуур

35. 30°C температуртай агаарын үнэмлэхүй чийг 25,22 гр/м³ байсан бол харьцангуй чийгийн хэмжээг олно уу. (үнэмлэхүй чийгийн багтаамж 30,38 гр/м³) **/2 оноо/**

- A. 83% B. 12% C. 55% D. 60% E. 25%

36. Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд оршдог 7689,4 мянган тонн цайр, хар тугалгын судлагдсан нөөцтэй стратегийн орд газар аль нь вэ? **/2 оноо/**

- A. Бороо B. Баянтээг C. Төмөртэйн овоо D. Бүрэнхаан E. Бэрх

37. Улс орнуудыг засаглалын хэлбэртэй нь харгалзуулна уу. **/2 оноо/**

1. Швед	a. Үндсэн хуульт хаант засаглал
2. Өмнөд Солонгос	b. Парламентийн БН засаглал
3. Брүней	c. Ерөнхийлөгчийн БН засаглал
4. Энэтхэг	d. Хэмжээгүй эрхт хаант засаглал

- A. 1-d, 2-c, 3-b, 4-a
B. 1-a, 2-c, 3-b, 4-d
C. 1-d, 2-a, 3-c, 4-b
D. 1-b, 2-d, 3-a, 4-c
E. 1-a, 2-c, 3-d, 4-b


38. 1952 онд байгуулагдсан. Төв нь Францын Страсбург хотод байрладаг. 27 гишүүн оронтой. Хороо, зөвлөл, шүүх, банк зэрэг тусгай үүрэг бүхий байгууллагууд, нэгдсэн мөнгөн тэмдэгттэй, бүс нутгийн эдийн засаг, хөгжлийг дэмжих зорилготой байгууллага аль нь вэ? **/2 оноо/**

- A. Умард Атлантын гэрээ B. Дэлхийн худалдааны байгууллага
C. Дэлхийн банк D. Европын холбоо E. Дэлхийн аялал жуулчлалын байгууллага



39. Хотгор гүдгэрийн хэлбэрийг хаялбар шугамаар зөв дүрсэлсэнтэй нь харгалзуулна уу.


/2 оноо/



- A. 1-d, 2-c, 3-b, 4-a
- B. 1-d, 2-a, 3-b, 4-c
- C. 1-a, 2-c, 3-b, 4-d
- D. 1-b, 2-a, 3-d, 4-c
- E. 1-c, 2-a, 3-b, 4-d

40. Хот байгуулалтын олон цөмт хэлбэрийг дүрсэлсэн зурагт 1 дугаараар ямар дүүргийн байршлыг харуулсан байна вэ?

/2 оноо/



- A. Орлого багатай иргэдийн орон сууцны хороолол
- B. Хүнд аж үйлдвэр
- C. Төвийн бизнес дүүрэг
- D. Баячуудын хороолол
- E. Дундаж орлоготой иргэдийн хороолол


41. Дээд ургамал ургахгүй зөвхөн хөвд, хаг ургадаг, хойд хагаст далай, өмнөд хагаст эх газар оршдог газарзүйн бүслүүрийг сонгоно уу.

/2 оноо/

- A. Сэрүүн бүслүүр
- B. Туйлын бүслүүр
- C. Халуун бүслүүр
- D. Экваторын бүслүүр
- E. Дулаан бүслүүр

42. Дэлхийн худалдааны газарзүйн зурагт ямар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ болон экспорт, импортын чиглэлийг дүрслэн харуулсан байна вэ?


/2 оноо/



- A. Нүүрс
- B. Цагаан будаа
- C. Чихрийн манжин, нишингэ
- D. Газрын тос
- E. Байгалийн хий

43. Дараах график нь аль хотын уур амьсгалыг илэрхийлж байна вэ?

/2 оноо/



- A. БНХАУ-ын Бээжин
- B. Индонезийн Жакарта
- C. ОХУ-ын Верхоянск
- D. АНУ-ын Сан Франциско
- E. Грекийн Афин



44. Дундаж зузаан нь 2200 км, 11 гр/см³ нягттай, температур нь 5000°C, даралт нь бодис хайлахад хүрэлцээтэй тул шингэн төлөвт оршдог дэлхийн гүний үе давхаргыг сонгоно уу. /2 оноо/

- A. Дотоод цөм В. Астеносфер С. Газрын давхарга
D. Манти Е. Гадаад цөм

45. Газарзүйн зурагт тодоор дүрслэгдсэн улс, бүс нутгийг зөв тодорхойлно уу. /2 оноо/



- A. Израйл, Өмнөд Ази
B. Гүрж, Баруун өмнөд Ази
C. Түрк, Зүүн өмнөд Ази
D. Иран, Баруун өмнөд Ази
E. Казахстан, Дундад Ази

46. Монгол улсын Гашуун Сухайт боомтоор аль улсын ямар нэртэй боомт хот руу шууд гарах вэ? /2 оноо/



- A. БНХАУ-ын Ганц мод
B. ОХУ-ын Хиагт
C. ОХУ-ын Хандгайт
D. БНХАУ-ын Зүүн хатавч
E. БНХАУ-ын Булган

47. БНХАУ-ын засаг захиргааны газарзүйн зурагт тодоор дүрслэгдсэн Өөртөө Засах Орны нэрийг олно уу. /2 оноо/



- A. Ганьсү муж
B. Төвдийн Өөртөө Засах Орон
C. Хөхнуур муж
D. Шинжаан-Уйгурын Өөртөө Засах Орон
E. Өвөр Монголын Өөртөө Засах Орон

48. Дэлхийн улс төр, эдийн засгийн харилцаанд голлох байр суурь эзэлдэг, программ хангамж, компьютер, анагаах ухаан, химийн үйлдвэрлэл, сансар судлал, зэвсэг, машин, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл болон молибден, мөнгө, цайрын нөөцөөр дэлхийд тэргүүлэгч улс аль нь вэ? /2 оноо/

- A. Индонез В. Куба С. Филиппин D. АНУ E. БНСУ

49. Аймгуудыг төвтэй нь тохируулаарай. /2 оноо/

1	Хөвсгөл	a	Эрдэнэт
2	Орхон	b	Чойбалсан
3	Дорнод	c	Мөрөн
4	Төв	d	Зуунмод

- A. 1-с, 2-а, 3-б, 4-д
B. 1-а, 2-б, 3-д, 4-с
C. 1-б, 2-а, 3-с, 4-д
D. 1-с, 2-а, 3-д, 4-б
E. 1-д, 2-с, 3-б, 4-а

50. Бэлчээрийн ургац 135 кг/га, нэг хонины хоногт идэх өвс 1.5 кг/га, бэлчээр ашиглах хугацаа 30 хоног бол цөлийн бүсийн бэлчээрийн даацыг нэгж талбайд идээшлэх малын тоогоор тооцоолоорой. /2 оноо/

- A. 5 хонь В. 13 хонь С. 3 хонь D. 11 хонь E. 20 хонь



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

1. Хариултын хуудасны санамж 2-р хэсгийг анхааралтай уншиж танилцаарай.
2. Даалгаврын хариуг даалгавар тус бүр дэх зааврын дагуу гүйцэтгэнэ үү.

2.1. ЗУ 40°-д орших Момбаса хотод Баасан гарагийн 10 цаг болж байхад БУ 140°-д орших Доусон хотод ямар гарагийн хэдэн цаг болж байх вэ? **/6 оноо/**

Алхам

- гариг [a] [Даваа бол 1, Мягмар бол 2, Лхагва бол 3, Пүрэв бол 4, Баасан бол 5, Бямба бол 6, Ням бол 7 цифрээр төлөөлүүлэн тэмдэглээрэй] /2 оноо/
- цаг [bc] /4 оноо/


2.2. Чойбалсан хотод цаг агаарын мэдээгээр агаарын даралт 786 гПа гэж зарласан бол D хотоос дээш хэдэн метр өндөрт оршиж байна вэ? (D хотод агаарын даралт 860 гПа)

Алхам

/6 оноо/


-агаарын даралтын зөрүү [ab], /2 оноо/

-хотын орших өндөр [cde] /4 оноо/



2.3. Өгөгдсөн дүрсийг ашиглан нуурын талбайг ойролцоогоор олж, км²-аар илэрхийлнэ үү.
Зургийн масштаб 1:250 000.

/6 оноо/



Алхам

-гурвалжингийн талбай [a] см², /2 оноо/

-тэгш өнцөгтийн талбай [bc] см², /2 оноо/

-масштаб ашиглаж олсон нуурын талбай [def] км²
/2 оноо/

2.4. Дараах улсуудыг албан ёсны хэлтэй нь зөв харгалзуулна уу.

/6 оноо/

Улс орнууд		Хэл	
a.	Сири, Оман	1	Испани
b.	Бразил, Ангол	2	Араб
c.	Гайти, Бенин	3	Англи
d.	Аргентин, Болив	4	Португал
e.	Тайвань, Хонконг	5	Хятад
f.	Шинэ Зеланд, Нигери	6	Франц

